




**“ ХАРИЛЦАА”-ны тухай ярилцсан санал-тэмдэглэл хэсэгт үзэл бодлоо илэрхийлээрэй.**



9.1а. Чиний хувьд хувь хүмүүсийн болон нийгмийн харилцааг хэрхэн тодорхойлох вэ?

9.1б. Чи дээрх ярилцлагад ямар тэмдэгт (эможи) дарах вэ?. Чиний сонгосон тэмдэгт ямар утга санаа илэрхийлж байгааг тайлбарлана уу.



9.1в. Дараах ойлголт болон тодорхойлолт, үг хэллэгийг зөв утгаар нь тохируулаарай.

1	Үгэн бус харилцааны онцлог	A	Давтах, зөрчилдөх, орлох, нэмэх, хүч нэмэх
2	Харилцаа	B	👉 Кувейтэд эн дохиог сөрөг утгаар хэрэглэдэг.
3	Харилцан үйлдлийн бэлгэ тэмдэг	C	Хэт ойр, эсвэл хэт хол байх
4	Үгэн бус харилцааны үүрэг	D	Хүмүүс хоорондын мэдээлэл солилцох үйл явц

A. 1b 2a 3c 4d    B. 1c 2d 3b 4a    C. 1c 2d 3a 4b    D. 1b 2c 3a 4d

9.1г. Дээрх санал-тэмдэглэл(подкаст)-д харилцааны ямар хэлбэр илэрч байна вэ?.

- A. Үгэн ба аман харилцаа                      B. Аман ба аман бус харилцаа  
C. Үгэн бус ба дохионы хэл                    D. Дохио зангаа ба биеийн хэл

**“ 30 секунд “-ын хөгжөөнт тоглоом тоглоцгооё**

Өгөгдсөн үгийг үг хэлэхгүйгээр үйл хөдлөлөөр үзүүлж ойлгуулна.

- Баярлах
- Гайхах
- Алагчлан хандах
- Чихнээс хонх уях

9.1д.Тоглоомд харилцааны ямар аргыг ашигласан бэ?.....

9.1е. Үйл хөдлөлөө үгэн бус аргаар илэрхийлсний давуу ба сул тал нь юу вэ?

.....

Тохиолдлыг шинжилж, асуултад хариулаарай.(Теле хичээлээ үзээрэй.)

Ерөнхий боловсролын нэгэн сургуульд “Спортын өдөрлөг-5 төрөлт” тэмцээн болж ангийн хүүхэд бүр оролцлоо. Тэмцээний журамд нэг сурагч нэг л төрөлд оролцохыг тодорхой заасан. Мөн анги хамт олны идэвх, оролцоо чухал учраас 9А ангийн хэсэг сурагч ангийнхнаа тэмцээний төрөл тус бүрээр багт хувааж нэрсийг гаргалаа. Гэтэл зарим сурагч тэмцээнд орохоос татгалзаж, зарим нь баг болж байгаа сурагчидаа үл хүндэтгэх, үзэл бодол нийлэхгүй байх зэрэг зохисгүй үйлдэл, зөрчил үүссэн.

9.1.ё. 9А ангийн сурагчид яагаад зөрчилдөх болов?. Өөрийн саналаа бичээрэй.

9.1ж. Чиний хувьд зөрчилдөөн гэж юу вэ?. Санал нийлж байгаа хэсгээ сонгоорой.

1. Хүмүүс хооронд мэдээлэл солилцох үйл явцын үр дүн
2. Хүмүүс хоорондоо санал үл нийлэх, үл ойлголцохоос үүссэн сөргөлдөөн
3. Үгэн ба үгэн бус харилцаа зөрчилдөх үйл явц

9.1з. Тохиолдолд ямар, ямар зөрчил, маргаан үүсч байна вэ?. Чиний бодлоор? Нэрлээрэй.

Чиний хувьд зөрчилдөөн үүсвэл хэр зэрэг зохистой, үр дүнтэй шийдвэрлэж чадах вэ? Өөртөө үнэлгээ өгөөрэй. Яагаад?

**Өөрийгөө үнэлээрэй:** 2 од хэсэгт гүйцэтгэсэн даалгавар бүрээс сайн ойлгосон, мэдсэн, чадснаа, 1 хүсэл хэсэгт ойлгоогүй, эргэлзсэн, дэмжлэг шаардлагатай даалгаврыг тус тус товч тодорхой бичнэ үү.

 2 од	 1 хүсэл	 Багшийн тэмдэглэл

Бүлэг сэдэв: **Хувь хүн ба нийгэм**  
Сурагчийн овог нэр:.....



9.2а. Хүмүүс хоорондын харилцаа нь харилцан үйлдлийн ямар хэлбэрээр илэрч байгааг үгэн ба үгэн бус харилцааны ойлголтыг ашиглан нөхөж бичээрэй. (сурах бичгийн 10 дахь тал. хүснэгт 2.1)

- |               |  |
|---------------|--|
| 1. ....       | A. Хүн эерэг үйлдэл хийснийхээ хариуд эерэг хариу хүсэх хандлага |
| 2. Өрсөлдөөн  | B. ....  |
| 3. ....       | C. Нэгэн зорилгод хүрэх үйл явц                                  |
| 4. Зөрчилдөөн | D. ....  |
| 5. ....       | E. Хэн нэгнийг хүчээр далайлган ямар нэгэн                       |

үйлдэл хийх үйл явц

9.2б. Монголчуудын мэндлэх ёсонд олон мянган жилийн уламжлалтай нүүдлийн амьдралын хэв маяг, харилцааны талаарх утга гүн шингэсэн байдаг. Дараах мэндчилгээ ямар утга санаа, бэлгэдэл илэрхийлж байгааг тайлбарлаж, жишээ гаргаарай. (сурах бичгийн 12 дахь тал.)

**“Намаржаа тавлаг уу”**

.....

**“Амар байна уу”**.....

.....

**“ Үйл уран болог ”**.....

.....




“Сур мэргэн үү”, “Морь хурдан уу”  
.....  
.....  
.....

9.2в. Тохиолдлыг шинжилнэ үү.

*Намайг Ц гэдэг. Би нэгэн сургуулийн 10-р ангид суралцдаг. Би хичээлдээ маш сайн, сургуульд сурлагаараа тэргүүлдэг сурагчдын нэг. Өнгөрсөн хавар төгсөгчдийн хонхны баярт сурагчдыг төлөөлөн үг хэлэхээр сонгогдлоо. Бусдын өмнө сайн ярьж чаддаггүй тул 5 хоног хэлэх үгээ бэлтгээд баяр дээр бэлтгэсэн 2 хуудас танилцуулгаа шууд л уншсан. Гэтэл тэнд байсан багш, сурагч, эцэг эхчүүдийн ихэнх нь намайг анхаараагүй нь мэдрэгдсэнээс гадна би өөртөө сэтгэл хангалуун бус байлаа. Учир нь дуу сул, өөртөө итгэлгүй санагдсан. Цаашид би яах вэ?. Надад зөвлөөрэй найзуудаа.*

- АСУУЛТ-ДААЛГАВАР**
- Нөлөөлсөн хүчин зүйлийг puzzle хэсэгт ногоон өнгөөр доогуур нь зурах эсвэл будаарай.
  - Тулгарсан бэрхшээлийг улаан өнгөөр доорх puzzle хэсэгт бичээрэй.
  - Харилцааны эерэг аргуудыг puzzle хэсэгт цэнхэр өнгөөр доогуур нь зурах эсвэл бичээрэй. (<https://www.zangia.mn/content/24147> сайтаас харилцааны эерэг аргуудыг уншиж судалаарай.)



9.2г .Чиний хувьд бусадтай харилцахад бэрхшээл тулгардаг уу?. Хэрвээ тулгардаг бол бэрхшээлээ давах харилцааны ямар эерэг аргуудыг ашиглах вэ?

---



---







---





---

**Өөрийгөө үнэлээрэй:** Гүйцэтгэсэн даалгаврын дугаарыг би хийж дууссан, би эргэлзэж байна, тусламж хэрэгтэй гэсэн хэсгүүдэд тэмдэглэнэ үү.

 <p>Би хийж дууссан</p>	 <p>Би эргэлзэж байна</p>	 <p>Надад тусламж хэрэгтэй байна</p>	 <p>Багшийн үнэлгээ</p>

Бүлэг сэдэв: **Хувь хүн ба нийгэм**  
Сурагчийн овог нэр:.....

9.3а. Энэтхэгчүүд эрт үед үхрийг Кришна бурхны хөлөг гэж шүтдэг байсан бол газар тариалан хөгжихийн хирээр ажлын гол хэрэгсэл болсон. Энэтхэгчүүдийн үхэртэй холбоотой ойлголтыг Монголчуудын адууг дээдлэх үзэлтэй харьцуулан дүгнэлт гаргаарай. (СБ. 9 дэх тал. эх сурвалж-2 )

---



---



---







---

9.36. Дараах тохиолдлыг харьцуулан шийдвэрлээрэй.  
(<http://mlctraining.mn/b/2096> сайтаас мэдээлэл аваарай.)

Тохиолдол	Бусадтай харилцахад тулгарч буй саад бэрхшээл	Бусадтай үр дүнтэй харилцах аргыг зөвлөөрэй.
А нь өөрийгөө их яриа, илэн далангүй, хүмүүстэй харилцахдаа сайн гэж боддог ч бусдад тэрээр түрэмгий, үзэл бодлоо тулгадаг мэт санагддаг.		
Л нь олны анхаарлын төвд орохыг хүсдэггүй. Хүсэж байгаагаа тэр бүр илэрхийлдэггүй надаас асууна гэж найддаг.		

**Өөрийгөө үнэлээрэй:** Сайн гүйцэтгэсэн даалгаврын дугаарыг “бие дааж хийсэн” хэсэгт, сурах бичиг ,теле хичээл үзэж судлаад хийсэн даалгаврын дугаарыг “уншиж судлаад дахин хийсэн” хэсэгт , эргэлзээтэй, ойлгомжгүй, чадаагүй даалгаврын дугаарыг “багшийн тусламж хэрэгтэй” гэсэн хэсэгт тэмдэглэнэ үү.

 Бие дааж хийсэн	 Уншиж судлаад дахин хийсэн	 Багшийн тусламж хэрэгтэй	 Багшийн дэмжлэг, чиглүүлэг хэрэгтэй

**“Хувь хүн ба нийгэм” бүлгийн өөрийн үнэлгээ**

1. Дараах ойлголтууд нь харилцааны ямар хэлбэрт хамаарахыг ангилан бичээрэй.  
**Биеийн хэл, бичгийн хэл, дохио зангаа, хэл яриа, нүүрний хувирал, нүдний харц**

2. Зөрчилдөөнийг шийдвэрлэхэд 2 шалгуур, 5 хандлага байдгийг тодорхойлсон эрдэмтэн хэн бэ?

A. К. Томас Р. Киллман                      В.Аристотель, А. Мехрабиан  
 С. М. Харрис, К. Томас                      D. А. Мехрабиан, Р. Киллман

- 3.Зөв ойлголт болон тодорхойлолтыг нөхөж бичнэ үү.

1. Хүмүүс хоорондоо мэдээлэл солилцох үйл явцыг..... гэнэ.
2. .... бол хоорондоо эсрэг тэсрэг шаардлагаас үүдэх сөргөлдөөн юм.
3. Харилцан үйлдэл нь харилцаан дахь .....-г хэлнэ.
4. Бусадтай үр дүнтэй харилцахад ..... ба ..... аргыг хослуулан хэрэглээрэй.

4. Монголчуудын мэндлэх ёсны төрөл болон мэндчилгээний хэллэгийг зөв тохируулна уу.

1. Өдөр тутмын мэндчилгээ                      А. Хожил хоёр тийшээ
2. Баяр ёслолын мэндчилгээ                      В. Тарган тавтай сайхан өвөлжиж байна уу?
3. Улирлын чанартай мэндчилгээ                      С. Үйл уран болог
4. Тоглоом наадмын мэндчилгээ                      D. Сур мэргэн, морь хурдан уу.
5. Ажил хөдөлмөрийн мэндчилгээ                      E. Сайн байна уу, амар байна уу

5. Харилцан үйлдлийн хэлбэрийг тохирох жишээтэй нь тохируулаарай.

1. Солилцоо                      А. Сагсны тэмцээндээ ялах нь чухал гэж дасгалжуулагч анхаарууллаа.
2. Өрсөлдөөн                      В. Батын vlog-д үе тэнгийнхэн нь өөрсдийн асуудлын талаар үзэл бодлоо илэрхийлдэг болсон.
3. Хамтын ажиллагаа                      С. Сөрөг харилцааг зөв шийдэж чадвал итгэлцлийг нэмэгдүүлэх зэрэг нөлөөтэй.
4. Зөрчилдөөн                      D. Батыг эцэг эхийн зүгээс хичээлдээ л анхаарахыг шаардсан.
5. Албадлага                      E. Бусдад туслах, бусдаас суралцах нь асуудлыг шийдвэрлэх хамгийн зөв гарц гэдгийг Бат ойлгосон.

A. 1b 2a 3d 4e 5c                      B. 1b 2a 3e 4c 5d                      C. 1b 2c 3e 4a 5d                      D. 1b 2c 3a 4d 5e

6. Үгэн бус харилцааны үүрэг, онцлог, давуу ба сул талуудаас 2,2-ыг бичнэ үү.

<b>Үгэн бус харилцаа</b>			
<b>Үүрэг</b>	<b>Онцлог</b>	<b>Давуу тал</b>	<b>Сул тал</b>

7. Зөрчил, маргааны холбогдолтой тохиолдлыг шинжлээрэй.


T найзтайгаа хамт нэг автобусаар өглөө эрт хичээлдээ явахаар тохирсон боловч найз нь хоёр ч удаа цагтаа ирэлгүй автобусаасаа хоцорчээ. Энэ удаа найзыгаа оройтож ирэхэд нь “Чи ямар сонин бэ, би чамтай дахиж хамт явахгүй” гэв.

<b>ӨДӨӨГЧ</b>	<b>ШАЛТГААН</b>	<b>ҮЕ ШАТ</b>	<b>ЗӨРЧИЛДӨГЧ ТАЛУУД</b>	<b>ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ</b>



Бүлэг сэдэв: **Хувь хүн ба соёл**  
 Сурагчийн овог нэр:.....


Эхэлсэн.... он....сар....өдөр....цаг  
 Дууссан.... он....сар....өдөр....цаг



9.1а. Монгол үндэстний соёлд хамаарах соёлын дугаарыг тэмдэглээд ямар соёл болохыг нэрлэж бичээрэй.



9.1б. Монголын үндэстний соёлоос соёлын өвд хамаарахыг нөхөж бичээрэй. (“Соёлын үнэт зүйлсийн тогтолцоо” сэдэвт теле хичээлээ үзээрэй.)



9.1.в Дээрх соёлын өвийг биет ба биет бус өвөөр ангилна уу. Соёлын биет ба биет бус өвийн тодорхойлолтыг бичээрэй. (СБ-ийн 29 дахь тал)

Соёлын биет өвийн нэр:	Соёлын биет өв гэж юу вэ?
Соёлын биет бус өвийн нэр:	Соёлын биет бус өв гэж юу вэ?

9.1г. Өнөө үед цахим хэрэглээ нь харилцаа, соёлын гол хэлбэр болсонтой санал нэг байна уу?. Яагаад? (СБ-ийн 37 дахь талын мэдээллийг ашиглаарай)

.....




.....

9.1д. Чиний хувьд цахим харилцаа гэж юу вэ?. Юуг хамааруулах вэ?. Нэрлэнэ үү.

.....

.....

**Өөрийгөө үнэлээрэй:** 2 од хэсэгт гүйцэтгэсэн даалгавар бүрээс сайн ойлгосон, мэдсэн, чадснаа, 1 хүсэл хэсэгт ойлгоогүй, эргэлзсэн, дэмжлэг шаардлагатай даалгаврыг тус тус товч тодорхой бичнэ үү.

 <b>2 од</b>	 <b>1 хүсэл</b>	 <b>Багшийн тэмдэглэл</b>

Бүлэг сэдэв: **Хувь хүн ба соёл**  
 Сурагчийн овог нэр:.....

9.2а. Үндэсний соёлоос нэгийг сонгон, сонгосон соёлынхоо утга учир, зан үйл, өвөрмөц онцлогийг тайлбарлаарай. (MNB. Монгол өв соёл цуврал нэтрүүлгийг сонирхож үзээрэй.)

9.2б. Дараах соёлын өвийг ямар аргаар судалдаг вэ?. Жишээ гаргаарай.

(СБ-ийн 29-30 дахь талаас ашиглаарай)

<p><b>Ардын аман зохиол</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Үлгэр, домог</li> <li>• Зуур, цэцэн үгс</li> <li>• Турган хэллэг</li> <li>• Дайралцаа үгс</li> <li>• Оньсого, таавар</li> <li>• Ерөнцийн гурав</li> <li>• Ерөөл, магтаал</li> <li>• Ардын уртын болон богинын дуу</li> <li>• Тууль</li> </ul> 	
	

Монгол угсаатны бүлгийн баяр наадам	9.2в. Хамтран ажиллаарай.		
	Ямар угсаатны ямар баяр болохыг нэрлээрэй	Ижил тал нь юу байна вэ?	Ялгаатай өвөрмөц ёс уламжлал нь юу байна вэ?

9.2г. “Монгол дахь хотжих үйл явц” судалгаатай танилцаад иргэд ёс заншлаа өвлөж буй өнөөгийн байдалд өөрийн үнэлгээг өгч, цаашид юу анхаарах талаар саналаа бичээрэй.




---



---



---



---



---


9.2д . Цахим орчинд үндэсний соёлоо эрхэмлэх, сурталчлах, эерэг нөлөөлөл үзүүлэх зорилгоор дараах ажлуудаас сонгон бусадтай хамтран хийгээрэй.

- **Челленж явуулах**
- **Подкаст ярилцлага хийх**
- **Блог хөтлөх, оролцох**
- **Зурагт хуудас, уриалга, зөвлөмж бэлтгэх**

**Дараах сайтыг үзээрэй**

- [1. http://www.ekids.mn/Home/newsdetail?dataID=22012](http://www.ekids.mn/Home/newsdetail?dataID=22012)
- [2. http://www.report.mn/16009/item](http://www.report.mn/16009/item)

**Өөрийгөө үнэлээрэй:** Гүйцэтгэсэн даалгаврын дугаарыг би хийж дууссан, би эргэлзэж байна, надад тусламж хэрэгтэй байна гэсэн хэсэгт тус тус тэмдэглэнэ үү.

 <p>Би хийж дууссан</p>	 <p>Би эргэлзэж байна</p>	 <p>Надад тусламж хэрэгтэй байна</p>	 <p>Багшийн үнэлгээ</p>

Бүлэг сэдэв: **Хувь хүн ба соёл**  
Сурагчийн овог нэр:.....



<p><b>9.3а. Бусад үндэстний соёлоос өвөрмөц ялгаатай байдгийн шалтгаан юу вэ?. Жишээгээр тайлбарлана уу.</b></p>	<p><b>9.3б. Чиний хувьд монгол хүн, монгол үндэстнээрээ бахархахын учир шалтгаан юу байдаг вэ?. Жишээгээр тайлбарлана уу.</b></p>
<hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>	<hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>

9.3в. Дэлхий нийтээрээ цахим хэрэглэгчид болсон. Дараах судалгааны тоон мэдээлэлд үндэслэн цахим хэрэглээ, гар утасны хэрэглээг тооцоолж, графикаар дүрслэн, тайлбарлаарай.

2017 онд “Харилцаа холбооны зохицуулах хороо”-ны гаргасан судалгаанд монгол улсын нийт хүн амын 1739181- 81%, үүнээс УБ-д 829454-85%, орон нутагт 909726-77% нь цахим хэрэглээ ашигладаг. Үүнээс: 15-20 нас 86%, 21-37 нас 84%, 38-52 нас 74%, 53-60 нас 68% байна. Гар утас хэрэглэгч 3168365-99,7%, үүнээс сурагчид 305084-71,8%, мөн facebook хэрэглэгч 91,2% байна. Манай улс facebook хэрэглэгчийн тоогоор дэлхийн дундажаас 2,1 дахин, Азийн улс орнуудаас 3,6 дахин их байна гэсэн судалгааг гаргажээ. Хуурамч мэдээ мэдээлэл хяналтгүйгээр цацагдаж мэдээллийн аюулгүй байдал, хүүхэд хамгаалал, бусдын нэр хүндэд халдах, залилан, донтолт зэрэг сөрөг зүйлс бий болсон нь оновчтой зохицуулалт шаардлагатай байна гэж дүгнэжээ.







9.1а. Дараах тодорхойлолтуудын ойлголтыг зөв нөхөн бичнэ үү.

**ХӨДӨЛМӨРИЙН  
ЗАХ ЗЭЭЛ**

**ЦАЛИН**

**АЖИЛЛАХ  
ХҮЧ**

**ХӨДӨЛМӨР**

Хөдөлмөрийн үнэ буюу хүний хөдөлмөрийг ашигласны төлөө төлж байгаа мөнгөн төлбөрийг ..... гэнэ. Ямар нэгэн ашигтай үр дүнд хүрэхэд чиглэсэн хүний оюуны болон биеийн үйл ажиллагааг ..... гэнэ. Ажиллах хүчний арилжаа солилцоо хийж буй хүрээг..... гэнэ. .... нь 16-аас дээш насны ажил эрхэлж байгаа болон бүртгэлтэй , хөдөлмөр эрхлээгүй хүмүүс бүрдэнэ.

9.1б. Хөдөлмөрийн зах зээлд бүртгэлтэй ажилгүй хүмүүсийн 60 гаруй хувь нь мэргэжлээрээ ажилдаггүй судалгаа гарчээ. Мэргэжил гэдэг нь ирээдүйн амьдралын удирдлага гэдэгтэй хэр санал нийлж байна вэ?

.....  
.....

9.1в. Эрэлттэй ажилд: мэдээлэл технологийн ажилтан, барилгын, уул уурхайн, автын инженер, өндөр зэрэглэлийн тогооч, гоо сайхны мэс засалч зэрэг багтжээ. Чиний сонгох гэж байгаа мэргэжил эрэлттэй мэргэжлийн жагсаалтад байна уу?

**Байгаа бол сонгосон үндэслэл:**

**Байхгүй бол эзэмших мэргэжлийн чиглэл юу?**

**Тухайн мэргэжилд шаардагдах сонирхол, авьяас чадвар юу байдаг вэ?**

9.1г.Тодорхойлолт бүрд тодруулсан үг зөв эсэхийг шалгаад алдаатай бол засна уу.

**Хуримтлал** нь бараа таваар эд баялгийн оронд төлбөр болгож авдаг солилцооны хэрэгсэл юм. **Хадгаламжийг** төв ба арилжааны гэж хоёр ангилна. Хуримтлалыг банк санхүүгийн байгууллагад данс нээлгэж байршуулсныг **мөнгө** гэнэ. **Банкыг** хугацаатай ба хугацаагүй гэж ангилна.

.....  
.....

9.1д. Мөнгөний төрлүүдийг нэрлээрэй.






.....

.....

.....


.....

**Өөрийгөө үнэлээрэй:** 2 од хэсэгт гүйцэтгэсэн даалгавар бүрээс сайн ойлгосон, мэдсэн, чадснаа, 1 хүсэл хэсэгт ойлгоогүй, эргэлзсэн, дэмжлэг шаардлагатай даалгаврыг товч тодорхой бичнэ үү.

 2 од	 1 хүсэл	 Багшийн тэмдэглэл

Бүлэг сэдэв: **Хувь хүн ба эдийн засаг**  
 Сурагчийн овог нэр:.....

9.2а. Дараах ойлголтуудын ангиллыг зөв нэрлэн бичиж, тайлбарлана уу.

















**Өөрийгөө үнэлээрэй:** Гүйцэтгэсэн даалгаврын дугаарыг би хийж дууссан, би эргэлзэж байна, надад тусламж хэрэгтэй байна гэсэн хэсэгт тус тус тэмдэглэнэ үү.

 <p>Би хийж дууссан</p>	 <p>Би эргэлзэж байна</p>	 <p>Надад тусламж хэрэгтэй байна</p>	 <p>Багийн үнэлгээ</p>

Бүлэг сэдэв: **Хувь хүн ба эдийн засаг**  
Сурагчийн овог нэр:.....



9.3а. Дараах даалгаврыг гүйцэтгэхдээ графикийн тайлбарыг сайтар ойлгоод ижил жишээг сурах бичгийн 44 дэх талын хүснэгт 1.1-ийг ашиглан хийгээрэй.

График	Тайлбар	Жишээ гаргаж, тайлбарлаарай
 <p>График 1.1. Хөдөлмөрийн эрэлтийн мөрүү <math>W(\text{wage})</math>-цалин</p>	<p>Цалин 200000 төгрөг байхад ажиллах хүчний тоо 500000 байна. Харин цалин 600000 төгрөг болоход ажиллах хүчний тоо 100000 болж буурч байна.</p>	
 <p>График 1.2. Хөдөлмөрийн нийлүүлэлтийн мөрүү <math>L(\text{Labor})</math>-Хөдөлмөрийн тоо хэлжээ</p>	<p>Цалин 400000 төгрөг байхад ажил хайгч (нийлүүлэлт) 300000 байсан. Харин цалин 200000 төгрөг болж буурахад нийлүүлэлт 100000 болж буурч байна.</p>	
 <p>График 1.3. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэр</p>	<p>F цэг дээр эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр үүсч байна. F цэгээс дээш эрэлт давсан тул ажиллах хүчний илүүдэл буюу ажилгүйдэл үүснэ.</p>	

Олон хувилбартай, алхамтай даалгавар гүйцэтгэхдээ багшаасаа заавар, чиглүүлэг, дэмжлэг аваарай. Эргэлзэх, ойлгомжгүй зүйл гарвал сурах бичгийн 45, 47, 50 дахь талыг уншиж судалаад дахин хийгээрэй.

9.36. Хүснэгтэд өгөгдсөн ойлголтуудыг тайлбартай нь харьцуулж, томъёог бичиж, жишээ гарган тооцоолоорой.

Ойлголт	Тайлбар	Томъёог бичээрэй	Жишээ гаргаж тооцоолоорой
1. Ажиллах хүчний оролцооны түвшин	Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог/ хөдөлмөрийн насны хүн амын тоонд хуваагаад 100% үржүүлнэ.		
2. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Хөдөлмөр эрхэлж буй хүний тоог/ хөдөлмөрийн насны хүн амын тоонд хуваагаад 100% үржүүлнэ.		
3. Гарт олгох цалин	Сарын цалингийн (нэрлэсэн цалин) хэмжээнээс НДШ-11,5%, ХХОАТ-10%, татварын хөнгөлөлт төлбөл зохих бусад татварыг хасна.		
4. Бодит цалин	Нэрлэсэн цалинг/ инфляцийн түвшинтэй харьцуулна.		
5. Ажилгүйдлийн түвшин	Бүртгэлтэй ажил хайж байгаа иргэдийн тоог/ эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулаад 100% үржүүлнэ.		



**Эргэцүүлэмж**

Аливаа юмс үзэгдэл, үйл байдлын учир шалтгаан, шинж чанарыг шүүн тунгааж, баталсан ба үгүйсгэсэн дүгнэлт гарган бичсэн эхийг хэлнэ. Эргэцүүлэмж нь баримт, нотолгоо, оюун дүгнэлт шаарддаг тул **дэвшүүлсэн асуудал, баталгаа, дүгнэлт** гэсэн хэсэгтэй байдаг.


9.3в. Мөнгө өөрийн үндсэн шинж чанараа алдвал ямар үр дагавартай байх талаар эргэцүүлэмж бичээрэй.

**Өөрийгөө үнэлээрэй:** Сайн гүйцэтгэсэн даалгаврын дугаарыг **“бие дааж хийсэн”** хэсэгт, сурах бичиг ,теле хичээл үзэж судлаад хийсэн даалгаврын дугаарыг **“уншиж судлаад дахин хийсэн”** хэсэгт , эргэлзээтэй, ойлгомжгүй, чадаагүй даалгаврын дугаарыг **“багшийн тусламж хэрэгтэй”** хэсэгт тус тус тэмдэглэнэ үү.


Бие дааж хийсэн	Уншиж судлаад дахин хийсэн	Багшийн тусламж хэрэгтэй	Багшийн дэмжлэг, чиглүүлэг



5. Иргэн Ж сард 700000 төгрөгийн цалин авдаг гэж үзээд цалингийн бүтэц, гарт олгох цалинг тооцоолоорой.



6. Графикийг ажиглаад хүснэгт дэх өгөгдлийн харьцааг олно уу.



Цалин	Хөдөлмөрийн эрэлт, ажиллах хүч
200 мянган төгрөг	500 ажиллах хүч
400 мянган төгрөг	? ажиллах хүч
? мянган төгрөг	100 ажиллах хүч